

Итгэлд бас мөрөөдөл бий

Саарал утаа ам ангайх төдийд хоолой хорсгож, тархи дүйнгэтүүлнэ. Өнөөх гайхал хаяанд ирснийг алтан тэвшийн хөндийн баруун хойд зүгт орших Баянхошуу, Баруун салааны айлуудын хар саарал гэрийн бүрээс, ханиаж хахах оршин суугчид гэрчлэх аж. Хэд хэд давхарласан цамц, хуучирч элэгдсэн пүүзтэй найм орчим насны хүү харанхуй гудамжид хальтарчихгүйг хичээн бөөвөгнөн алхсаар сургуульдаа ирлээ. Түүнийг Итгэл гэдэг бөгөөд Нийслэлийн ...-р сургуулийн 3-р ангид суралцдаг.

Хичээлийн цаг эхэлж багш “Дүрслэх урлаг ба технологи”-ийн хичээл орон хүүхдүүдийг зургийн дэвтэр, өнгийн харандаагаа гаргахыг хүслээ. Итгэлийн цүнхэнд бүрэн хавтаслаагүй гурван дэвтэр, хугарсан харандаа, бэх нь гоожсон бал, шаазан аяга, төмөр халбаганаас өөр зүйл байсангүй. Ширээний найз нь түүнд зургийн дэвтрийнхээ голоос урж өгөөд, өнгийн будгаа хамтдаа хэрэглэхийг уриална. Тэр зурах дуртай ч хараас өөр өнгийн харандаатай байж үзээгүй билээ. Цагийн зүү урссаар үдийн цайны хонх жингэнэх нь тэр. Өнөөдрийн үдийн цайнд ямар хоол өгөх нь Итгэлийн хувьд чухал мөчүүдийн нэг. Учир нь боов боорцог, печень, талх зэргийг өгсөн өдрүүдэд цүнхэлж, гэрээ сахин үлдсэн дүүдээ аваачиж өгнө. Өнөөдөр мушгиа боорцог, нэг аяга аарц өгсөн учраас боорцгоо ганц хоёр хазчихаад цүнхэлж, аяганд дах аарцаа уух нь тэр. Тарах цаг хэдийнээ болоход хам хум сандчин гарч дүү рүүгээ яарлаа.

Гэртээ үлдсэн дөрвөн настай Мишээл халтайж хуучирсан хүүхэлдэйгээр гэрийнхээ хойморт тоглон, бээрэх гараа үрэн хөнжилдөө шургаж жаахан дулаацах ажээ. Уг нь энэ гэр бүл дөрвөн гишүүнтэй боловч ээж нь тэднийг орхин нутаг буцаж аав, хүү, охин гурав үлдсэн. “Аав архи уугаад ирэхээрээ ээжийг цохьдог. Тийм болохоор ээж дандаа уйлдаг бас өвдсөөр байгаад явчихсан” хэмээн өнөөх дөрвөн наст шулганан ярина. Монгол улсын Засгийн газрын 2023 оны зургаадугаар сарын 21-ний өдрийн 236 дугаартай тогтоолоор “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн олгох журам”-ыг шинэчлэн баталсны дагуу сар бүр олгодог 100,000 төгрөг эзэндээ очдог эсэх нь эргэлзээтэй. “Аав хааяа зөндөө мөнгөтэй болдог. Тэр үедээ бид хоёрт чипс, ундаа авч өгдөг” гэж Итгэл өгүүлнэ. Тэдний хажуу айлын хүн М.Баярмаа “Эдний хоёр хүүхэд манай хүүхдүүдтэй нэг үе. Хааяа хамт тоглочихсон л гүйж яваа харагддаг.

Том нь жаахан хувцас муутай юм шиг болохоор нь хүүхдийнхээ хуучирсан цамц өмдийг илүүчлэхийг хичээнэ. Аав нь архины хамааралтай болоод удаж байна. Эхнэрээ байнга л зодож цохиж, хардаж сэрдсээр байгаад явуулчихсан. Өөрөө уг нь “Самушил” гээд хөдөлмөр зуучилдаг компанид ажилладаг. Өдөр өдөртөө өөр өөр газар очин өгсөн ажлыг нь хийгээд цалингаа бэлнээр авдаг болохоор уучхаад ирдэг бололтой. Өвөл барилгын ажил зогсохтой зэрэгцэн өнөөх зуучлалын компани ч үйл ажиллагаагаа зогсоодог. Одоогоор эрхэлсэн ажилгүй, хоног өдрийг аргацаасан л хүн харагддаг. Хүүхдийн 100,000 орсон өдрүүдэд бүр завсаргүй ууна гээч” гэж ярина. Монголд 57 гэрлэлт тутмын 12 нь салж байна гэсэн статистикийн баримт бий. Энэ нь 5 хүүхдийн нэг нь өнчин өсч байна гэсэн үг юм. Гэр бүлийн тухай хуулийн 26-р зүйлийн 2.2-т эцэг эх нь хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргийг хүлээнэ” гэж заасан байдаг ч энэ биелэгдэхгүй байгаа юм.

Аав нь хааяа эрүүл байж хоол хийдэг “азтай” өдрийн нэг нь өнөөдөр. Орой болж айлуудын яндангаас гарах утаанд сүүмийсэн “Нархан” дэлгүүр лүү зүглэсээр ирлээ. Дэлгүүрт ороод хоёр ширхэг төмс, нохойн хоол буюу хонины цувдай, хагас хил цагаан будаа нэмээд 0.5 литр хэмжээтэй “Хараа” хэмээн томоор бичигдсэн архи худалдаж аваад халаас руугаа хийчихнэ тэр. Хольж хутгаад хоол болгоод идчихдэг гэр нь дулаахан, гэдэс цатгалан, өдрүүд тийм ч их биш. Түрүүн халаасласан шил архиа уусан аав нь удалгүй агсарч эхэлнэ. Итгэлд гэрийн даалгавраа хийх боломж бараг л гарахгүй. Цүнхэнд байсан гурван дэвтрийн нэг нь хэдийнээ дуусчихсан. Итгэл том болоод алдартай зохион бүтээгч болохыг мөрөөддөг.

Сонгинохайрхан дүүргийн 7-р хорооны нийгмийн ажилтан О.Алтантуяа “Заримдаа дүн өвлийн хүйтэнд хүүхдээ гадаа зогсоож, өөрсдөө дотор архидсан айлуудтай олон таардаг. Тэдний нэг нь эднийх. Охиныг нь цэцэрлэгт хамруулсан боловч удалгүй гаргачихсан байсан. Бид хэдий хараа хяналтандаа авч үүргээ гүйцэтгэж байгаа ч дэргэд нь лаа бариад зогсож байхгүйгээс хойш бүтэн хянаж чаддаггүй. Ийм айлууд ч олон бий. Зарим нь үр хүүхдээ хүн харахын эцэсгүй болгож зодчихсон байдаг юм. Шалбарч, хөхөрсөн гар хөл, нүүр царайнаас илүү амьдралд бууж өгч, айж цочирдсон нүдний харц л өр өвдмөөр. Гэр бүл төлөвлөлт бол өнөөгийн хөндөх ёстой асуудлуудын нэг болчихсон. Нэгэнт эцэг, эхийн үүргээ биелүүлж тэжээж чадахгүй бол олон хүүхэдтэй болохоо болих хэрэгтэй” гэлээ.

Хүүхэд хорвоод ирмээр байна гэж ирдэггүй. Ирүүлэх эсэх нь бидний гарт байдаг сонголт. Цав цагаан, хир толбогүй цэвэрхэн цаасыг хэн болгож нийгэмд өгөх нь бидний үүрэг, хариуцлага бас ухамсар. Хорт утаа, давчидмаар түгжрэл, ээлгүй хот төлөвлөлт, чанаргүй эрүүл мэнд, боловсроогүй боловсрол гээд асуудлууд түм их. Гэхдээ энэ нийгмийг бүтээх ирээдүйн эзэд хүүхдүүд чинь ямар орчинд өсөх, хэн болох, юу идэх, хэрхэн эрүүл байх зэрэг нь улаан дохиолол асаамаар нэгт бичигдэх асуудал мөн. Тэд хүссэн болохоор хорвоод ирээгүй. Ирсэн ч архины хамаарал, аав ээжийн үл хайхрах хүчирхийлэлд өртөх ёсгүй. Нэг хороонд, нэг дүүрэгт, нэг хотод хэдэн мянган Итгэл байгааг бид мэдэхгүй.

МУИС-ийн СЗОНХТ-ийн 3-р түвшний оюутан: М.Лхагвадулам